

**ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ҮНЭ /5-р сарын 28-наас 6-р сарын 25-ны байдлаар, төгрөгөөр/**

№	Барааны нэр, төрөл	V/28	VI/04	VI/11	VI/18	VI/25
1	Гурил, I зэрэг, кг	920	920	920	920	1000
2	Хонины мах, кг/ ястай/	8000	7500	7500	7500	7500
3	Үхрийн мах, кг /ястай/	9000	9000	10000	10000	10000
4	Ямааны мах /ястай /	6500	6500	6500	6500	6500
5	Элсэн чихэр, кг	1700	1700	1700	1700	1700
6	Цагаан будаа, кг	2150	2150	2150	2150	2150
7	Шингэн сүү, л	1200	1000	800	800	800
8	Ямааны ноолуурын үнэ 1 кг- цагаан	65000	65000	60000	60000	60000
9	- Бор ноолуур	65000	65000	60000	60000	60000
10	Бензин, А-80, 1 литр	1570	1570	1570	1570	1570
11	Бензин, А-92, 1 литр	1690	1690	1690	1690	1690
12	Дизелийн түлш, 1 литр	1790	1790	1790	1790	1790

Гол нэрийн барааны үнийн 7 хоногийн мэдээгээр аймгийн төвд 2014 оны 5-р сарын 28-наас 2014 оны 6-р сарын 25-ны хооронд ямааны ястай мах, элсэн чихэр, цагаан будаа, шатахууны ханш тогтвортой байсан бол “Алтан тариа” ХК-ийн 1-р гурил, хонь үхрийн ястай мах, шингэн сүү, ноолуурын үнэ тогтвортой байлаа.

**Махны үнэ.** 5-р сарын 28-нд хонины ястай мах 1 кг нь 8000 төгрөг байсан бол 6-р сарын 4-нөөс 6,25 хувь буюу 500 төгрөгөөр буурч 7500 төгрөг болсон нь 6-р сарын 25-ныг хүртэл хэвээр байна. Үхрийн ястай мах 5-р сарын 28-наас 6-р сарын 4-ныг хүртэл 9000 төгрөгийн байснаа 6-р сарын 11-нээс 6-р сарын 25-ныг хүртэл 10000 төгрөгийн ханштай байна. Ямааны ястай мах энэ хугацаанд 6500 төгрөгийн ханштай байна.

**Гурил, элсэн чихэр, цагаан будаа.** “Алтан тариа” ХК-ийн 1-р гурил 6-р сарын 25-наас 1000 төгрөг болж өмнөх 7 хоногоос 8,7 хувиар өслөө. Элсэн чихэр, цагаан будааны үнэ сүүлийн 5 долоо хоногийн турш тогтвортой байна.

**Шингэн сүү.** Дулааны улирал ирж сүүний нийлүүлэлт ихэсч байгаатай холбоотойгоор шингэн сүүний үнэ сүүлийн 5 долоо хоногийн хугацаанд хоёр удаа буурав. 6-р сарын 4-нд өмнөх долоо хоногоос 16,7 хувиар, 6-р сарын 11-нд өмнөх 7 хоногоос 20 хувиар тус тус буурч 800 төгрөг болов.

**Ямааны ноолуур.** Энэ хаврын ноолуурын арилжаа 3-р сарын дундуур 1 кг нь 75000 төгрөгийн ханштай эхэлсэн ба 6-р сарын 4-нд 65000 төгрөг, 6-р сарын 11-нд 60000 төгрөг болж буурав.



